

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ  
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2020 оны 12 дугаар сарын 31

Улаанбаатар хот

**НЭГ." БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН"**

**1.1 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг үндэслэн тус дүүргийн харьяа төсөвт байгууллагууд, хувийн хэвшлийн цэцэрлэг, сургууль, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

**1.2 Дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл;**

Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5 дугаар хэсгийн 5.3.4 Дүүргийн нутгийн захирагааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж хэвшүүлэхэд хяналт тавих 5.3.5 Дүүргийн нутгийн захирагааны байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулах замаар ажлын байрны эмх, цэгц, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх тогтолцоонд бүрэн шилжүүлсэн эсэхэд хяналт тавих гэсэн заалтуудын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2020 онд 14 аудит хийхээр төлөвлөсөн. 72 дугаар цэцэрлэг, 243 дугаар цэцэрлэг, 49 дүгээр цэцэрлэг, 27 дугаар цэцэрлэг, 28 дугаар цэцэрлэг, 230 дугаар цэцэрлэг, 53 дугаар цэцэрлэг, 26 дугаар сургууль, 10 дугаар сургууль, Соёлын ордон, АгроФарк, Худалдан авах ажиллагааны алба, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг нийт 14 аудитыг хийж төлөвлөөний биелэлтийг 100% хангаж ажиллалаа. Мөн иргэн Жаргалаас ирүүлсэн гомдоор 73 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж дүгнэлт гаргасан.

**Аудитын үр дүн:**

Аудит хийсэн байгууллагуудад одоогийн байдлаар нийт 440,940.1 мянган төгрөгийн 71 зөвлөмж, 11.535,5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,993.8 төгрөгийн 2 акт тогтоож ажиллалаа. Өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын дагуу байгууллага бүр биелэлтийг хангах төлөвлөгөө гарган албан тоотоор биелэлтийг авч хэрэгжилд хяналт тавьж ажиллалаа.

Албаны аудиторуудтай ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах гэрээ байгуулан байгууллагуудад шалгалтаар орохын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үссэн тохиолдолд зөрчил үссэн тухай 12 мэдэгдэл гаргуулан баталгаажуулсан.

**ХОЁР "ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН":**

**2.1 Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл:**

**2.1.1** "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээ"-ний тухай Нийслэлийн Засаг даргын 2015 оны 1 дүгээр сарын 8-ний өдрийн А/01 захирамжийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж мэдээллийг бүрэн оруулгуулснаар 2019 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулан ажиллалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчид сар бурийн 15-ны дотор эрхлэх асуудлын хүрээний төсвийн 65 байгууллагын өмнөх сарын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг гарган танилцуулж ирлээ. Мөн улирлаар мэдээлэл байршуулдаг

хувийн хэвшлийн 95 цэцэрлэг, 20 сургууль, 15 өрхийн эмнэлэгийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн улирал бүрийн мэдээг Засаг даргад танилцуулж тайланг Сангийн яаманд хүргүүлж ажиллалаа.

Захирамжлалын баримт бичгийн гүйцэтгэлийн мэдээг 1-4 дүгээр улирлаар гаргаж цахим болон цаасан хэлбэрээр Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүллээ.

### ГУРАВ "БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН":


#### 3.1 Байгууллагын хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

##### 3.1.1 Хяналт шалгалтын ажлын хүрээнд:

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт, Нийслэлийн Дотоод аудитын хорооны 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоолыг үндэслэн тус дүүргийн 2019 онд байршуулсан мэдээлэлд хяналт шалгалт хийж нийслэлийн Дотоод аудитын албандаа загвар хүснэгтийн дагуу хүргүүлж ажиллалаа.

##### 3.1.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд:

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг үндэслэн тус дүүргийн харьяа төсвийн байгууллагууд, хувийн хэвшлийн цэцэрлэг, сургууль, өрхийн эзүүл мэндийн төвүүдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. 65 төсөвт байгууллага, 20 хувийн сургууль, 95 хувийн цэцэрлэг, 15 өрхийн эзүүл мэндийн төв нийт 195 байгууллага мэдээлэл оруулахаас 195 байгууллага шилэн дансны цахим хуудсанд мэдээллээ бүрэн орууллаа.



Хан-Уул дүүргийн харьяа төсвийн байгууллага, хувийн цэцэрлэг, сургууль, ӨЭМТөвүүдийн тоо 2018 онд 178 байгууллага, 2019 онд 187 байсан бол 2020 онд 195 байгууллага болж нэмэгдсэн байна.



2020 онд Хан-Уул дүүргээс нэг хүүхдэд ногдох хувьсах зардал шинээр авах цэцэрлэг, сургуулиудын нягтлан бодогчидод сургалт зохион байгуулж, мэдээлэл хэрхэн оруулах талаар зохион байгуулж системд нэврэх эрхийн кодыг өгч ажиллалаа.



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах зорилгоор Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн мэдээллийн самбар хийж байрлууллаа. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллүүдийг хянаж самбарт байршуулж ажилласнаар мэдээлэл хоцроох, огт оруулахгүй байх зерчил эрс буурсан.

#### Facebook.com/XUD Нягтлан бодогчид

ХУД Нягтлан  
бодогчид  
■ Secret Group  
About  
Discussion  
Members  
Events  
Videos  
Photos  
Files  
Search this group Q  
Joined Notifications Add Members More

Төсвийн байгууллагуудын мэдээлэл оруулахтай холбоотой шинэчлэл, өөрчлөлтүүд, тулгарч буй хүндрэл асуудлуудыг Facebook.com/XUD Нягтлан бодогчид гэсэн группээр харилцаж шийдвэрлэж ирлээ.

#### Facebook.com / ХУД Хувийн хэвшлийн цэцэрлэг сургуулиуд

ХУД Хувийн  
хэвшлийн  
цэцэрлэг, сургууль  
■ Closed Group  
About  
Discussion  
Members  
Events  
Videos  
Photos  
Files  
Group Insights  
Manage Group  
Joined Notifications Share More

Мөн хувийн хэвшлийн цэцэрлэг, сургуулиудын Шилэн дансны мэдээлэл оруулахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Facebook.com/ХҮД Хувийн хэвшлийн цэцэрлэг сургуулиуд гэсэн групп нээн одоо 500 гишүүдтэй ажиллуулж байна.

### Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл хоцроож оруулсан байгууллагууд



### Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын талаар:

Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/30 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 2020 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин шаардлагатай арга хэмжээг авч ажиллалаа. Шалгалтаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Хуулийн хугацаа хоцроож мэдээлэл байршуулах
- Хөрөнгө, мөнгө зарцуулсан шийдвэрийг дутуу мэдээлэх
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг дутуу мэдээлэх
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг дутуу мэдээлэх зэрэг зөрлүүдийг хяналтын явцад залруулууж ажилласнаар 2020 оны 1 дүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн ханггуулж ажиллалаа.



Ажлын хэсэг 2020 оны 5 дугаар сарын 6, 7-ний өдрүүдэд 6 сургууль, 6 цэцэрлэг нийт 12 байгууллагын үйл ажиллагаа ажиллагаатай танилцаж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг загвар хүснэгтийн дагуу шалгаж гаргасан алдаа дутагдал, дахин хуулийн хугацаа хоцроож мэдээлэл оруулахгүй байх зэрэг асуудлыг дахин гаргахгүй байх талаар сануулга өгч ажиллалаа.

### **3.1.3 Албаны бусад ажлын талаар:**

Албаны сайтад тухай бүр шинээр гарсан хууль эрх зүйн акт, олон нийтийн ажил, хурал цуглаан, сургалтад хамрагдсан мэдээлэл, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор аудиторын зөвлөмж, албаны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр оруулан ажиллаж байна.

Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд албаны дарга О.Одгэрэл тухай бүр өөрийн биеэр сууж өгсөн үүрэг даалгаврыг албаны шуурхай дээр танилцуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Албаны шуурхай зөвлөгөөнийг хийж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргуулан хяналт тавьж ажиллаж ирлээ.

Дотоод аудитын олон улсын стандартуудыг шинэчлэх, практикт хэрэглэж дутагдалтай талуудыг шинэчлэн Сангийн яаманд санлаа хургуулэн цаашид илүү боловсронгүй болгох талаар ажиллаж байна.

Дүүргийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэх ажлын хүрээнд бэлтгэл ажлыг бүрэн хангаж амжилттай дүгнүүллээ.

Дотоод аудитын албанаас Хан-Уул дүүргийн хэмжээнд хийгдэж буй дараах төсөл хөтөлбөр арга хэмжээ, барилга, засварын ажилд хяналт тавьж ажиллалаа. Үүнд:

- 75 дугаар сургуулийг буулгах барих
- 65 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих
- 65 дугаар цэцэрлэгийн камержуулалт
- 65 дугаар цэцэрлэгийн сангийн засварын ажил
- 46 дугаар цэцэрлэг биеийн тамирын талбай /гадна талд/
- 72 дугаар цэцэрлэг тоног төхөөрөмжийн засвар

2020 онд 152 албан бичгийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж зөрчилгүй ажилласан.

### **Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа:**


2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 12-13 цагийн хооронд зөвлөлийн дарга Ү.Шинэтер, гишүүн Б.Амарбаясгалан, гишүүн Б.Нямсүрэн нарийн бүрэлдэхүүнтэйгээр албаны даргын өрөөнд хуралдаж 2 асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Үүнд:

- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2020 оны төлөвлөгөөг шинэчлэн батлах
- Актлах хөрөнгийн жагсаалтыг хагас жилийн тооллогоос өмнө Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлэх зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ.


2020 оны 6 дугаар сарын 6-ны өдөр зөвлөлийн дарга Ү.Шинэтер, гишүүн Б.Амарбаясгалан, гишүүн Б.Нямсүрэн нарийн бүрэлдэхүүнтэйгээр албаны даргын өрөөнд хуралдаж 2 асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Үүнд:

- Тоног төхөөрөмжийн данснаас 3 нэр төрлийн 3 ширхэг 1,325.0 мянган төгрөгийн хөрөнгө хасах тухай
- Тавилга эд хогшил данснаас 1 нэр төрлийн 3 ширхэг 420.9 мянган төгрөгийн хөрөнгө хасах тухай
- Хангамжийн материалын данснаас 13 нэр төрлийн 22 ширхэг 873,3 мянган төгрөгийн хөрөнгө хасах тухай нийт 17 нэр төрлийн 28 ширхэг 2,619,2 мянган төгрөгийн хөрөнгийн бүртгэлээс хасаж актлахаар шийдвэрлэлээ.

### Албан хаагчдын мэргэшсэн байдал 2017-2020



### Албан хаагчийн ажилласан жилийн судалгаа



Тус алба нь тайлант онд хүний нөөцийн талаар ил тод байдлыг хангахад албан хаагч тус бүрийн сурч боловсрохыг хүсч байгаа талаар санал бодлыг чөлөөтэй сонс ч тэднээс төлөвлөгөөг нь гаргуулан авч ажилласан.

Албан хаагчдаас нийт давхардсан тоогоор 13 төлөвлөгөөг боловсруулсан бол, 4 дүгээр улирлын байдлаар давхардсан тоогоор 7 чиглэлд сурч боловсорч мэдлэгээ дээшлүүлсэн амжилттай байна.

Шагнал урамшуулалд 8 албан хаагчдыг 8,100.3 мянган төгрөгөөр урамшуулсан бол, нийгмийн баталгааг хангахад давхардсан тоогоор 8 албан хаагчдыг 4 223.6 мянган төгрөгийн тусламж дэмжлэгийг үзүүлж иржээ.

Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцлийг бүрдүүлэхэд 806 тоот өрөөнд 1 ширхэг агаар хөргүүрийг 299.9 мянган төгрөгөөр авч ажилчдын ажиллах нөхцлийг сайжруулсан байна.

Мөн covid19 томуугын үед албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалахад 834.7 мянган төгрөгийн өртөг бүхий нэг удаагийн маск, гар ариутгагчийг албан хаагчдад олгож урьдчилан сэргийлсэн.

Одоогоор сул орон тоо байхгүй, хүний нөөцийн ил тод байдлыг хангах талаарх цахим хуудсанд бүх мэдээллийг байршуулж ирсэн.

Сангийн яамнаас дотоод аудитын аргачлал, чанарын үнэлгээний аргачлал, олон улсын сайн туршлагууд болон дотоод аудит, хяналт шалгалтыг гүйцэтгэхэд анхаарах асуудлын талаар улсын салбарын дотоод аудиторууд, санхүүгийн хяналтын улсын байцаагч нарыг хамруулсан "Улсын салбарын дотоод аудиторуудын зөвлөгөөн – 2020"-ийг Улаанбаатар хотод 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнд бүх албан хаагчид бүрэн хамрагдлаа



Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар, нийслэл, дүүргүүдийн дотоод аудитын албадын дунд зохиогдсон спортын 3 төрөлт тэмцээнд амжилттай оролцож дартсын төрөлд алтан медаль өргөмжлөлөөр шагнагдлаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны сонгуулийн Хан-Уул дүүргийн 29-8-1 дүгээр хэсгийн хороонд гишүүнээр ажиллалаа.

#### **ДӨРӨВ "БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ":**

##### **4.1 Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл.**

Албаны веб сайтад албаны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухай бүр байршуулж ажиллалаа.

Албаны сайтад байршуулсан мэдээллүүд:

- Тесвийн гүйцэтгэлийн мэдээ
- Байгууллагын батлагдсан тесөв
- Дүүргийн харьяа байгууллагуудын нягтлан бодогчдын мэдлэгийг сайжруулах зорилгоор шинэчлэгдсэн хуулийн тухай мэдээлэл
- Нийслэл дүүргэс зохион байгуулсан олон нийтийн ажилд оролцсон тухай танилцуулга
  - Албаны өдөр тутмын үйл ажиллагаандaa мөрдөж буй хуулийн жагсаалт
  - Байгууллагын Шилэн дансны мэдээлэл
  - Байгууллагын эрхэм зорилго, танилцуулга

- Ажилчдын мэдээлэл
- Шилэн дансны мэдээлэл оруулах гарын авлага зэрэг мэдээллүүдийг байршуулж байгууллагын төсөв санхүү, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажилласан.



**Албаны төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд цаг хугацаанд нь бүрэн оруулж ажилласан.**



Албаны веерийн Шилэн дансны цахим хуудсанд 2020 оны 1-11 дүгээр сарын байдлаар оруулах ёстой 137 мэдээллэлийг хуулийн хугацаанд бүрэн оруулж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.

#### ТАВ. "БУСАД МЭДЭЭЛЭЛ":

##### 5.1 Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээлэл;

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулуулах зорилгоор ХУД Хувийн хэвлэлийн цэцэрлэг сургуулиуд гэсэн группийг нээн одоо 500 гишүүнтэй болсон.

Төсвийн байгууллагуудын мэдээлэл оруулахтай холбоотой шинэчлэл, веерчлелтууд, тулгарч буй хүндрэл асуудлуудыг Facebook.com/XUD Нягтлан бодогчид гэсэн группээр харилцаж шийдвэрлэж ирлээ.

Шилэн дансны хуулийг сурталчилж мэдээлэл хэрхэн оруулах талаар зөвлөгөө өгч хамтарч ажиллаж байна. Урьд нь байгууллага нэг бүртэй утсаар холбогдож мэдээлэл өгдөг байсан нь цаг хугацаа алдаж холбооны зардал их гарах шалтгаан болж байсан бол одоо асуудал бүрэн шийдвэрлэгдлээ.

##### Төсөв санхүүгийн талаар:

2020 онд 212,085.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 197,085.1 мянган төгрөгийг зарцуулж 15,000.0 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан.

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогийг хугацаанд нь тайланг хүргүүллээ.

2. Нийгмийн даатгал болон, татвар, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад хүргүүлж өр авлагчийг ажилласан.

3. Санхүү, төрийн сангийн хэлтэст тайлан, мэдээг тухай бүр хугацаанд нь хүргүүлж ажилласан.

##### 5.2 Нийслэл дүүргээс зохион байгуулсан ажилд оролцсон тухай:

Хан-Уул дүүргийн Дотоод аудитын албаны ажилтан албан хаагчид 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Оргил худалдааны төвийн замын 2 талыг цэвэрлэв.



Нийслэлийн, дүүргийн Засаг даргын шуурхай штаб ажиллуулах захирамжийн хүрээнд 7 албан хаагч давхардсан тоогтоор 8 удаа үүрэг гүйцэтгэж ажилласан.



Нийслэлийн, дүүргийн Засаг даргын эргүүл жижүүр ажиллуулах захирамжийн хүрээнд 16, 21 дүгээр хороон дээр 5 албан хаагч давхардсан тоогтоор 8 удаа үүрэг гүйцэтгэж ажилласан.



➤ Тоног төхөөрөмжийн данснаас 3 нэр төрлийн 3 ширхэг 1,325.0 мянган төгрөгийн хөрөнгө хасах тухай

➤ Тавилга эд хогшил данснаас 1 нэр төрлийн 3 ширхэг 420.9 мянган төгрөгийн хөрөнгө хасах тухай

➤ Хангамжийн материалын данснаас 13 нэр төрлийн 22 ширхэг 873,3 мянган төгрөгийн хөрөнгө хасах тухай нийт 17 нэр төрлийн 28 ширхэг 2,619,2 мянган төгрөгийн хөрөнгийн бүртгэлээс хасаж актлахаар шийдвэрлэлээ.

2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 15-16 цагийн хооронд зөвлөлийн дарга У.Шинэтер, гишүүн Б.Нямсурэн нар хангамжийн материалын данснаас 13 нэр төрлийн 22 ширхэг 873,3 мянган төгрөгийн ашиглах боломжгүй болсон хөрөнгийг бүртгэлээс хасч устгалаа.



ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ

АУДИТОР УШИНЭТӨР

ХЯНАСАН:

ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ

ДАРГА О.ОДГЭРЭЛ

ТУЗ1325 1118270246 5813506